

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Суат” орон нутгийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2023/02/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Б.Үүрийнтуяа

Утас: 90832211 Цахим хаяг: uuriintuya.b@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Төлбөрийн акт	16
5.2 Албан шаардлага.....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ХСУХАТАУЗЗ	Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

“СУАТ” ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ
КОМПАНИЙ ЗАХИРАЛ Ж.АДАЛБЕК ТАНАА

2023.08.15 № 186
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Суат” орон нутгийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Суат” орон нутгийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна..

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Компанийн урт хугацаат зээлийн үлдэгдлээс 331.0 сая төгрөгийг суутган төлүүлсэнтэй холбоотой урт хугацаат ер төлбөр 660.0 сая төгрөг болж буурсан.Богоно хугацаат өглөг 331.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	773,714.74	15,047,718.59
1.1.2	Дансны авлага	221,130,096.58	161,214,667.41
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		
1.1.4	Бусад авлага	300,000.00	830,000.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	50,992,647.74	64,263,651.08
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	12,310,193.85	13,106,593.85
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	285,506,652.91	254,462,630.93
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	6,797,052,388.14	6,759,498,260.22
1.2.2	Биет бус хөрөнгө	1,063,478,199.98	1,729,445,299.92
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	7,860,530,588.12	8,488,943,560.14
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	8,146,037,241.03	8,743,406,191.07
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр	283,801,667.05	598,778,276.09
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	283,801,667.05	598,778,276.09
2.1.1.1	Дансны өглөг	36,167,875.95	24,062,468.67
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	234,506,312.30	192,745,344.29
2.1.1.4	НДШ – ийн өглөг	13,127,478.80	17,010,935.88
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүгийн өглөг		33,900,871.25
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц/өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		331,058,656.00
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) -нд хамаарах өр төлбөр		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	283,801,667.05	598,778,276.09

(үргэлжлэл)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
---------------	----------	------------------------	------------------------

“Суат” орон нутгийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудит

2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	991,058,656.00	660,000,000.00
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	991,058,656.00	660,000,000.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,274,860,323.05	1,258,778,276.09
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	3,295,181,962.17	4,102,142,939.17
2.3.2	· хувийн		
2.3.3	· хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	4,505,765,988.90	4,505,765,988.90
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(929,771,033.09)	(1,123,281,013.09)
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	6,871,176,917.98	7,484,627,914.98
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	8,146,037,241.03	8,743,406,191.07

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,245,059,684.66	1,344,152,131.89
2	Борлуулалтын өртөг	1,070,484,500.00	1,293,493,911.89
3	Нийт ашиг(алдагдал)	174,575,184.66	50,658,220.00
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	205,549,957.44	244,168,200.00
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(30,974,772.78)	(193,509,980.00)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(30,974,772.78)	(193,509,980.00)

“Суат” орон нутгийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудит

21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(30,974,772.78)	(193,509,980.00)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	3,295,181,962.17		4,505,765,988.90		(898,796,260.31)	6,902,151,690.76
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						
3	Залруулсан үлдэгдэл	3,295,181,962.17	-	4,505,765,988.90	-	(898,796,260.31)	6,902,151,690.76
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)					(30,974,772.78)	(30,974,772.78)
5	Бусад дэлгэрэнгүй орлого						-
6	Өмчид гарсан өөрчлөлт	720,120,626.00					720,120,626.00
7	Зарласан ногдол ашиг						-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						-
9	2021 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	3,295,181,962.17	-	4,505,765,988.90	-	(929,771,033.09)	6,871,176,917.98
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						-
11	Залруулсан үлдэгдэл	3,295,181,962.17	-	4,505,765,988.90	-	(929,771,033.09)	6,871,176,917.98
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					(193,509,980.00)	(193,509,980.00)
13	Бусад дэлгэрэнгүй орлого						-
14	Өмчид гарсан өөрчлөлт	665,463,000.00					665,463,000.00
15	Зарласан ногдол ашиг						-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						-
17	2021 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	3,960,644,962.17	-	4,505,765,988.90	-	(1,123,281,013.09)	7,343,129,937.98

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	1,239,948,710.14	1,533,556,229.71
1.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,239,948,710.14	1,533,556,229.71
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		

“Суат” орон нутгийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудит

	Бусад мөнгөн орлого		
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,219,021,632.62	1,484,327,101.66
	Ажиллагчдад төлсөн	376,881,939.58	503,124,857.60
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	142,994,383.19	163,136,534.68
	Бараа материал худалдан авахад төлсөн	25,330,221.81	52,033,762.26
	Ашиглалтын зардалд төлсөн	309,749,181.34	262,601,557.60
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	64,128,735.05	138,356,847.84
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	132,733,424.95	201,348,102.52
	Даатгалын төлбөрт төлсөн	5,194,650.00	5,412,825.00
	Бусад мөнгөн зарлага	162,009,096.70	158,312,614.16
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	29,555,300.00	34,955,124.20
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого		
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	29,555,300.00	34,955,124.20
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(8,628,222.48)	14,274,003.85
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,401,937.22	773,714.74

“Суат” орон нутгийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудит

7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	773,714.74	15,047,718.59
---	---	------------	---------------

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төгрөгөөр

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 оны гүйцэтгэл	2022 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт						
	Борлуулалтын орлого цэвэр ус	төгрөг	471,637,250.0	579,271,470.0	593,595,180.2	14,323,710.2	102.5
	Борлуулалтын орлого бохир ус	төгрөг	422,791,830.0	509,700,482.3	516,137,593.4	6,437,111.1	101.3
	Борлуулалтын орлого халуун ус	төгрөг	148,280,514.4	168,879,054.3	180,254,126.4	11,375,072.1	106.7
	Бусад борлуулалтын орлого	төгрөг	202,350,090.0	65,411,309.0	54,165,232.0	(11,246,077.0)	82.8
2	Нийт орлого		1,245,059,684.4	1,323,262,315.6	1,344,152,132.0	20,889,816.4	101.6
	Үүнээс: Цэвэр борлуулалт		1,245,059,684.4	1,323,262,315.6	1,344,152,132.0	20,889,816.4	101.6
3	Нийт зардал		1,276,034,457.4	1,469,617,635.1	1,537,662,112.9	68,044,477.8	104.6
	Үүнээс:					-	
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		1,068,313,319.4	1,235,778,623.1	1,293,493,912.9	57,715,289.8	104.7
	б) Ерөнхий ба удирдлагын зардал		207,721,138.0	233,839,012.0	244,168,200.0	10,329,188.0	104.4
	в) Хөрөнгө оруулалт их засвар		-	-	-		
4	Цэвэр ашиг, алдагдал		(30,974,773.0)	(146,355,319.5)	(193,509,980.9)	(47,154,661.4)	132.2

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

“Суат” ХХК-нийн зорилго нь хэрэглэгчдийг ундны ахуйн стандартын шаардлага хангасан цэвэр усаар найдвартай хангаж хэрэглээний явцад гарсан бохир усыг татан зайлуулж, хөнгөн шуурхай, сэтгэл ханамжтай үйлчилгээ үзүүлэхэд оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг “Өлгий сумын хэрэглэгчдийг стандартын шаардлагад нийцсэн ундны ахуйн цэвэр усаар хангах, гарсан бохир усыг зайлуулан цэвэрлэх, нийтийн халуун усаар үйлчлэх, инженерийн байгууламжийн жигд найдвартай ажиллагааг хангах, гарсан авар ослыг богино хугацаанд арилгаж усны алдагдлыг багасгах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллана” гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Хязгаарлагдмал хариуцлагатай компани статустай байна. Өмчийн 100 хувийг төр, үүнээс 100 хувь орон нутгийн өмч байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

“Суат” ХХК нь анх 1952 онд АДХ-ын Гүйцэтгэх захиргааны дэргэд “Үйлчлэх товчоо” нэртэйгээр байгуулагдаж, 1999 оноос бүтцийг өөрчилж “Суат” ХХК нэртэйгээр байгуулсан байна.

“Суат” орон нутгийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудит

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор томилж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалттай нийцэж байна. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 103 тоот тогтоолоор ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг 7 гишүүнтэйгээр шинэчлэн тогтоосон байна.

“Суат” ХХК -нийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 5.7 сая төгрөгөөр тогтоосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж заасан байна. Энэ хүрээнд хийгдсэн арга хэмжээ байхгүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд ороогүй байна.

Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2021 оны 07 дугаар сарын 21-ны өдрийн 67 тоот тогтоолын 1 хавсралтад заасны дагуу 2022.01.01-нээс айл өрхийн цэвэр бохир ус тарифыг нэмэгдүүлсэн байна.

Тайлант онд УАГ-ын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу тус компанийн үйл ажиллагааны үр ашиг сэдэвт аудитаар 2018-2021 оныг хамруулан гүйцэтгэлийн аудит хийгдсэн байна. Аудитын дүнгээр НӨАТ-ын төсөвт дутуу төвлөрүүлэлттэй холбоотой 47.8 сая төгрөгийн акт тогтоосноос 10.0 сая төгрөгийг барагдуулсан. Компанийн үйл ажиллагааны хяналттай холбоотой 6.2 сая төгрөгийн албан шаардлага өгөгдсөнийг биелэлтийг ирүүлсэн байна.

Дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Суат” ХХК-ний 20 тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн БӨА-2023/02/НА-СТА-ОНА

“Суат” орон нутгийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудит

байна. “Суат” ХХК-ний 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл/мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Компанийн мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Тус компани нь захирлын тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг 2020 оны 01 дүгээр сарын 01-нээс мөрдөж ажилласан байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Суат” ХХК-ний 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 455.9 сая төгрөгөөр буюу 5.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөгөөр/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	773.7	15,047.7	14,274.0
Авлага	221,430.1	162,044.7	(59,385.4)
Урьдчилгаа	12,310.2	13,106.6	796.4
Бараа материал	50,992.6	64,263.7	13,271.0
Үндсэн хөрөнгө	7,860,530.6	8,347,445.6	486,915.0
Нийт хөрөнгө	8,146,037.2	8,601,908.2	455,871.0
Богино хугацаат өглөг	283,801.7	598,778.3	314,976.6
Урт хугацаат өглөг	991,058.7	660,000.0	(331,058.7)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,871,176.9	7,343,129.9	471,953.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	8,146,037.2	8,601,908.2	455,871.0

Эх сурвалж: Аудитын судалгаа

Мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, урт хугацаат өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 15.0 сая төгрөг болж 14.3 сая төгрөгөөр өссөн байна. Үүнээс кассын үлдэгдэл 4.7 сая, 10.4 сая төгрөгийн арилжааны банкны мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Авлагын дансны үлдэгдэл 162.0 сая төгрөгөөр буюу 59.4 сая төгрөгөөр буурсан байна. Авлага буурахад төрөөс хариуцах цэвэр, бохир усны төлбөрийн хүрээнд үүссэн айл өрх, ААНБ-аас авах 49.5 сая төгрөгийн авлага барагдсан нь нөлөөлсөн байна.

“Суат” орон нутгийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудит

Авлагын үлдэгдэлд төлөгдөх хугацаандаа байгаа 154.5 сая төгрөгийн, хугацаа хэтэрсэн 7.5 сая төгрөгийн найдваргүй авлага байна.

Авлага дансны үлдэгдэлд 2011 оноос хойш үүссэн, үйл ажиллагаа нь зогссон, дампуурсан аж ахуйн нэгжтэй холбоотой олон жил болсон 7.5 сая төгрөгийн он дамжсан авлагыг найдваргүй авлагын дансанд бүртгэх арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 0.8 сая төгрөгөөр өссөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 64.3 сая төгрөг болж 13.3 сая төгрөгөөр өссөн нь түүхий эд материалын үлдэгдэл 4.7 сая, БҮТЭЗ-ийн материал 8.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь худалдаж авсан аж ахуйн материал үлдэгдэлтэй гарснаас шалтгаалжээ.

Тайлант онд 38.2 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 24.9 сая төгрөгийн материалыг зарцуулж, оны эцэст 64.2 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй гарч, бараа материал өмнөх оноос 13.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна. Оны эцэст их хэмжээний худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгээгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 486.9 сая төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Тайлант онд 35.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авсан, 700.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгөөр нэмэгдсэн нь 656.5 сая төгрөгийн газар эзэмших эрхийг биет бус хөрөнгөөр бүртгэж, орлого авсантай холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 598.8 сая төгрөг болж 315.0 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд:

Богино хугацаат өр төлбөр дансанд урт хугацаат өр төлбөр данснаас Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл дансанд 331.1 сая, зээлийн хүүгийн өглөгт 33.9 сая төгрөгийн аймгийн орон нутагт төлөх өглөгтэй холбоотой их хэмжээгээр нэмэгдсэн.

Сангийн яам 2022 онд тус компанийн урт хугацаат зээлийн төлбөрт 331.0 сая төгрөгийг аймгийн орон нутгийн төсөв олгох санхүүгийн дэмжлэгээс суутган төлүүлснийг богино хугацаат өглөгөөр бүртгэж тайлагнасан байна.

Өмнөх оны жилийн эцсийн өглөг 50.0 сая төгрөгөөр буурсан нь цалингийн өглөг 0.2 сая, НӨАТ-т 46.4 сая, түлш халаалт, гэрэл цахилгааны өглөг 11.9 сая төгрөгөөр буурч өглөг буурахад нөлөөлсөн. Харин ХХОАТ-ын өглөг 4.2 сая, ус ашигласны төлбөрт 0.4 сая, НДШ-д 3.9 сая төгрөгөөр нэмэгдэж оны эцэст нийтдээ 233.8 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна.

Компанийн 2001 оноос хойш үүссэн урт хугацаат зээлээс тайлант онд 331.0 сая төгрөгийг суутган төлүүлсэнтэй холбоотой урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 660.0 сая төгрөг болж оны эхнээс 331.0 сая төгрөгөөр буурсан байна.

Энэ нь Азийн Хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн “Орон нутгийн хотуудын Нийтийн аж ахуйг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд тус аймагт цэвэр бохир усны системийн техник, технологийг шинэчлэх цэвэр усны шугам хоолойг өргөтгөх, цэвэр бохир усны насосын станц, 30 хүний халуун усны барилгад их засвар хийх, 3 ба 5 хүний халуун ус барих, ус түгээх, 2 ш гүний худаг барих, машин техник нийлүүлэх, цэвэрлэх байгууламжид био цөөрмийн карт барих зэрэг ажлуудад хийгдсэн хөрөнгө оруулалт байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, ерөнхий ба удирдлагын зардал гэж

“Суат” орон нутгийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудит

ангилсан байна. Зардлыг өмнөх онтой харьцуулахад нийт зардал 128.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь цалин хөлс, тээвэр шатахууны зардлууд нэмэгдсэн.

Тайлант онд 193.5 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, 656.5 сая төгрөгийн газар эзэмших эрхийг биет бус хөрөнгөөр бүртгэж, орлого авсантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс нийт дүнгээр 472.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Суат” ХХК-нийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Суат” ХХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 01 тоот тогтоолоор компанийн бүтэц, орон тооны дээд хязгаарыг 01 дүгээр хавсралтаар, цалингийн фондыг 2 дугаар хавсралтаар, 2022 оны бизнес төлөвлөгөөг 3 дугаар хавсралтаар, үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсан байна.

“Суат” ХХК-ны зүгээс “Хот суурины ус хангамж ариутгах татуургын зохицуулах зөвлөл”-д 2022 оны санхүүгийн төлөвлөгөөг хүргүүлсэн байна.

“Суат” ХХК-ны 2022 оны нийт орлогыг 1,323.2 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,469.6 сая төгрөгөөр, 146.4 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 20.0 сая төгрөгийг төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 1344.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,537.7 сая төгрөгийн зардал гарган, -193.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Гүйцэтгэлээр нийтдээ 1344.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж орлогын төлөвлөгөөг 20.9 сая төгрөгөөр буюу 1.6 хувиар давж биелэгдсэн нь хэрэглэгчдийн тоо нэмэгдсэнээс шалтгаалж усны хэрэглээ нэмэгдсэн, төсөвт байгууллагын үнэ тариф өөрчлөгдсөн зэрэг нь нөлөөлсөн байна.

Компаний нийт зардлын гүйцэтгэл 1537.7 сая төгрөгт хүрч төлөвлөснөөс 68.0 сая төгрөгөөр буюу 4.6 хувиар хэтэрсэн байна. Үүнд ажилчдын цалин нэмэгдсэн, үнэ ханш нэмэгдсэнтэй холбоотой тээвэр шатахуун, цахилгаан, түлш халаалтын зардал, бусад зардал нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

“Суат” ХХК нь тайлант онд 193.5 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, алдагдлыг төлөвлөснөөс 47.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Энэ нь Азийн хөгжлийн банкны урт хугацаат зээлийн хүүгийн өглөг нэмэгдсэнтэй холбоотой байна.

Борлуулалтын орлого өмнөх 99.1 сая төгрөгөөр буюу 8.0 хувиар өссөн нь өмнөх оноос айл өрх, орон сууцны цэвэр, бохир усны тариф нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 261.7 сая төгрөгөөр буюу 20.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Өмнөх оноос цалин хөлс, гэрэл цахилгаан, тээвэр шатахууны зардлууд, зээлийн хүүгийн өглөг өссөн байна.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 01 тоот тогтоолоор орон тооны дээд хязгаарыг 74 орон тоогоор, ажилчдын цалинг 10 хувиар тогтоож баталсан.

Урсгал засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 15 нэр төрлийн шугамын урсгал засвар хийж, өөрийн хөрөнгөөр 34.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

“Суат” орон нутгийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудит

Компани нь тайлант онд НДШ-ийн ногдуулалтын алдангид 6.1 сая төгрөгийг, татварын өглөгийн алдангид 2.7 сая төгрөгийг, Шүүхийн шийдвэрээр харуул хамгаалалтын компанид 5.2 сая төгрөгийг, нийтдээ 14.0 сая төгрөгийг төлж төлөвлөгдөөгүй, үр ашиггүй зардал гаргасан байна.

“Суат” ХХК нь Засгийн газраас төрөөс хариуцсан цэвэр, бохир усны төлбөрөөс авлагаар бүртгэсэн 130.3 сая төгрөгийг тайланд онд авч, дээрх үр ашиггүй зардлуудыг гаргаагүй байсан бол санхүүгийн тайлангаар ашигтай гарах боломж байсан байна.

Тус компани нь 3, 5, 30 хүний халууны усны үсчин, 2 халуун усны байрны түрээс, хуучин конторын барилгын 2 өрөөг түрээсийн гэрээгээр өгч түрээсийн орлого оруулдаг байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Суат” ХХК-ний 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх компани түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компанийн орлогыг нэмэгдүүлэх, үр ашиггүй зардлуудыг бууруулах замаар аймгийн орон нутгийн төсөвт төлөх урт хугацаат зээлийн төлбөртэй холбоотой өр төлбөрийг барагдуулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

“Суат” ХХК-ний 2022 оны санхүүгийн тайланг 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 21 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг “Суат” ХХК-ний 2021 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө 8,146.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 162.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 114.0 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор арга хэмжээ ажиллаагүй дараах зөрчил гарсан байна. Үүнд:

1. Бэлэг дурсгал, шагнал, урамшуулал, хүлээн авалтын зардалд 12,839.7 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулж үргүй зардал гаргасан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав.

Суат ХХК нь 2022 онд нийт 1022.5 сая төгрөгийн 152 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас бүрэн мэдээлсэн хэрэгжилтийн хувь 100% байна.

Тус аудитын газраас 2022 оны 11 дүгээр сард эхний 9 сарын мэдээллийн шалгаж, зөрчлийг арилгуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд асуудал гараагүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “Суат” ХХК-д 0.8 сая төгрөгийн акт тогтоож, Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2069.7 сая төгрөгийн 20 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 1 улирлын мэдээллийг оруулаагүй, өмнөх оны аудитаар шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчилд албан шаардлага, тайлант онд борлуулалтын орлого, сар бүрийн түрээсийн орлогоос нийтдээ 91.5 сая төгрөгийг касст БӨА-2023/02/НА-СТА-ОНА

“Суат” орон нутгийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудит

бэлнээр орлого авч, банкин дахь харилцах дансанд тушаахгүйгээр шууд зарцуулсныг зөвлөмж өгөгдсөн.

Аудитаар хэрэгжилтийг давтан шалгахад өмнөх зөрчлийг 100.0%-ийн биелэлттэй байна. Шилэн данстай холбоотой алдаа, зөрчлийг давтан гаргасан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	819.0	1	819.0	100.0
Албан шаардлага	1	2,069,755.2	1	2,069,755.2	100.0
Зөвлөмж	1	91,479.1	1	91,479.1	100.0
Нийт дүн	3	2,162,053.3	3	2,162,053.3	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ Аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой алдаа¹ илрээгүй. Аудитаар нийт 37.8 сая төгрөгийн алдаа² илэрснээс аудитын явцад залруулах алдаа гараагүй байна.

Аудитаар нийт **37.8** сая төгрөгийн зөрчил илэрч **37.8** сая төгрөгийн албан шаардлага, 1 зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй байна.

5.2 Албан шаардлага

Аудитаар дараах зөрчилд албан шаардлага өгөгдсөн. Үүнд:

1. Бэлэг дурсгал, шагнал, урамшуулал, хүлээн авалтын зардалд 12.8 сая төгрөгийн хөрөнгө зарцуулж үргүй зардал гаргасан байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Компанийн урт хугацаат зээлийн төлбөртэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Сангийн яам 2022 онд компанийн урт хугацаат зээлийн үлдэгдлээс 331.0 сая төгрөгийн аймгийн орон нутгийн төсвөөс суутган төлүүлсэнтэй холбоотой урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдлийг 660.0 сая төгрөг болж бууруулж бүртгэн, богино хугацаат өглөгийг 331.0

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

“Суат” орон нутгийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудит

сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь цаашид компанийн үйл ажиллагаанд эрсдэл учруулахаар байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Компанийн орлогыг нэмэгдүүлэх, үр ашиггүй зардлуудыг бууруулах замаар аймгийн орон нутгийн төсөвт төлөх урт хугацаат зээлийн төлбөртэй холбоотой өр төлбөрийг барагдуулах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Урт хугацаат зээлийн төлбөртэй холбоотой аймгийн орон нутгийн төсөвт төлөх өр төлбөр нэмэгдсэн.	1	0.0					1	0.0				
Дүн	1						1	0.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Үүнээс		Зөвлөмж	
					Албан шаардлага		Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								

“Суат” орон нутгийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудит

Дүн								
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
1. Бэлэг дурсгал, шагнал, урамшуулал, хүлээн авалтын зардалд хөрөнгө зарцуулж үргүй зардал гаргасан байна.	1	12,839.7			1	12,839.7		
Дүн	1	12,839.7			1	12,839.7		
Нийт дүн	1	12,839.7			1	12,839.7		